



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 01 сарын 25 өдөр

Дугаар А/42

Улаанбаатар хот

Хоол, унааны нөхөх төлбөрийн хэмжээг
шинэчлэн тогтоох тухай

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1, 27.1.3, 29.2.4 дэх заалт, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.7, 8.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 "Төрийн албаны хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1995 оны 60 дугаар тогтоолын 2, Байгууллагын даргын 2016 оны 255 дугаар тушаалаар баталсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 9 дүгээр зүйлийн 9.21-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гадаадын иргэн, харьяатын газрын албан хаагчдын ажлын нэг өдөрт олгох хоолны нөхөх төлбөрийн хэмжээг 5500 төгрөгөөр, унааны нөхөх төлбөрийн хэмжээг 500 төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосугай.

2. Албан хаагчдын хоол, унааны нөхөх төлбөрийг 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн тооцож олгохыг Санхүүгийн хэлтэс /Б.Даваажав/-т зөвшөөрсүгэй.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан "Хоол, унааны хөнгөлөлтийг нэмэгдүүлэн олгох тухай" Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрын даргын 2011 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн А/451 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /М.Төрбат/-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨРӨН

00001534